

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2012 оны 8-р сарын 22-ны байдлаар*


2012 оны 8-р сарын 22-ны байдлаар гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 1.0 хувиар буурсан бол, өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 0.1 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 2.6-4.5 хувь, адууны махны үнэ 3.9 хувь, хонины махны үнэ 5.2 хувиар буурсан бол, ямааны махны үнэ 0.1 хувиар өссөн байна.

Махны үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад үхрийн ястай махны үнэ 2.2 хувь, хонины махны үнэ 0.5 хувь, ямааны махны үнэ 1.7 хувиар өссөн бол, адуу болон үхрийн цул махны үнэ тогтвортой байв.

2012 оны 8-р сарын 22-ны байдлаар 1 кг хонины /ястай/ махны үнэ дунджаар 7075 төгрөг, хонины цул мах 7460 төгрөг, үхрийн /ястай/ мах 7814 төгрөг, үхрийн цул мах 8788 төгрөг, ямааны мах 5820 төгрөг, адууны мах 6083 төгрөгийн үнэтэй байлаа (Зураг 1; 2).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ **Зураг 2.** Цул махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад “Алтан тариа” ХК-ны задгай 1-р зэргийн гурил 0.3 хувиар өссөн бол, савласан дээд гурилын үнэ тогтвортой байв. Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад гурилын үнэ тогтвортой байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар элсэн чихрийн үнийг өмнөх сарын үнэтэй харьцуулахад 2.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цагаан будааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 2.5 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна (Зураг 3).

Зураг 3



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 16.8 хувь, сонгины үнэ 4.7 хувиар өссөн бол, байцааны үнэ 36.4 хувь, луувангийн үнэ 1.9 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 0.7 хувь, сонгины үнэ 5.1 хувиар өссөн бол, луувангийн үнэ 22.2 хувиар буурсан байна. Төмсний үнэ тогтвортой байна.

Сүү, өндөг, ургамлын тос, цөцгийн тосны дундаж үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад задгай сүүний үнэ 8.4 хувиар өссөн бол, 1 литрийн савлагаатай сүүний үнэ 1.0 хувь, 0.5 литрийн савлагаатай сүүний үнэ 6.1 хувиар буурчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад задгай сүүний үнэ 4.1 хувиар өсчээ.

Ургамлын тосны үнийг өмнөх сарын үнэтэй харьцуулахад 0.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цөцгийн тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 3.4 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, хонь, ямаа, үхрийн мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 600-950 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Баян-Өлгий, Сүхбаатар аймагт 10-60 төгрөгөөр өсчээ.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 600 төгрөг байхад, Хөвсгөл аймагт 950 төгрөг байгаа нь өндөр үнэ байлаа.

Махны үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар хонины махны дундаж үнэ өмнөх 7 хоногийнхоос Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Булган, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт 100-1000 төгрөгөөр буурсан бол, Архангай, Хэнтий аймагт 200-300 төгрөгөөр өсчээ. Хонины махны үнэ 5300-7000 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна. Хонины махны үнэ Баян-Өлгий, Өмнөговь, Ховд аймагт 7000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байгаа бол, Баянхонгор аймагт 5300 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий аймагт 200-600 төгрөгөөр буурсан бол, Архангай, Дорноговь аймагт 100-350 төгрөгөөр өссөн байна. Үхрийн махны үнэ Говь-Алтай, Өвөрхангай аймагт 8000 төгрөг буюу хамгийн өндөр үнэтэй байхад, Баянхонгор аймагт 5800 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байлаа.

Ямааны махны үнэ Баян-Өлгий, Ховд, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Дорнод аймагт 300-600 төгрөгөөр буурсан бол, Өвөрхангай, Говьсүмбэр аймагт 100 төгрөгөөр өссөн байна. Ямааны махны үнэ Говь-Алтай, Баянхонгор аймагт хамгийн хямд буюу 4500 төгрөг байхад, Өмөговь, Ховд аймагт 6500 төгрөг буюу хамгийн өндөр үнэ байлаа.

Малын сүүний үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар малын сүү аймгуудад 500-1725 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Сүүний үнэ Ховд, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл, Төв аймагт 50-100 төгрөгөөр өссөн бол, Увс, Дорноговь, Дундговь, Дорнод аймагт 100-300 төгрөгөөр буурч, бусад аймагт тогтвортой байв.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2012 оны 8-р сарын 22-ны байдлаар цагаан будааны үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Увс, Ховд, Говьсүмбэр, Өмнөговь аймагт 100 төгрөгөөр өсч, Дундговь аймагт 30 төгрөгөөр буурлаа. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 1400-2000 төгрөгөөр худалдаалагдсан байна.

Элсэн чихрийн үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад Говьсүмбэр аймагт 100 төгрөгөөр өссөн бол, бусад аймагт тогтвортой байлаа. Аймгуудад элсэн чихэр 1 кг нь 1500-1800 төгрөгийн хооронд худалдаалагдсан байна.